

БНМАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН
ГАДААД ХАРИЛЦАА, ХАНГАМ-
ЖИЙН ЯАМНЫ САЙДЫН ТУШААЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

1989 оны 4 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 143/77

Улаанбаатар
хот

Төмөр 1989 228
Ашиглалтын өмнөх түр захиргаа
байгуулах тухай

БНМАУ-ын Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хорооны 1989 оны 4 дүгээр сарын II-ний өдрийн I47 дугаар тогтоолыг үндэслэн БНМАУ-ын эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яамны коллеги, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Төв аймгийн нутагт байрлаж байгаа, Зөвлөлтийн цэргийн ангийн "Мааньт" хотхоныг хүлээж авах, ажлын бэлтгэлийг хангах ашиглалтын өмнөх түр захиргааг нэгдүгээр хавсралтанд дурдсан орон тоотойгоор байгуулж 1989 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн ажиллуулсугай.

2. Мааньт хотхоныг Зөвлөлтийн талаас хүлээж авах бэлтгэлийг хагуулах, холбогдох асуудлыг судалж боловсруулах комиссыг хоёрдугаар хавсралтанд дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

3. Уул объектыг комиссын бүрэлдэхүүнээр газар дээр нь үзэж танилцсаны үндсэн дээр материал хангамж, тээврийн зарим байгуулагыг хотоос гаргаж байршуулах, шинээр байгуулах замаар тосгоны хэмжээнд хүн амын бүх төрлийн үйлчилгээтэй байхаар бодож зохион байгуулах саналыг энэ оны 5 дугаар сарын 15-ны дотор боловсруулж дуусгахыг комиссын дарга нөхөр Л. Энэбишид даалгасугай.

4. Мааньт хотхоны ашиглалтын өмнөх түр захиргааг байгуулж байгаатай холбогдуулан шаардагдах зардлын төсвийг зохиож БНМАУ-ын Сангийн яаманд оруулж батлуулахыг БНМАУ-ын Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яамны орлогч сайд П. Бадрал, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга нөхөр Л. Энэбиш нарт даалгасугай.

БНМАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН
ГАДААД ХАРИЛЦАА, ХАНГАМ-
ЖИЙН ЯАМНЫ САЙД

Н. ОЧИРБАТ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА

С. МӨНХМАРТАЛ



БНМАУ-ны Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1989 оны 4 дүгээр сарын 15 -ны өдрийн хамтарсан хурлын 143/77 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

МААНЬТ ХОТХОНЫ АШИГЛАЛТЫН ӨМНӨХ
ЗАХИРГААНЫ ОРОН ТОО

Албан тушаал	орон тоо
1. Ашиглалтын өмнөх захиргааны дарга	1
2. Орлогч дарга	1
3. Хариуцлагатай нарийн бичгийн дарга	1
4. Орон сууц, нийтийн аж ахуй, шугам сүлжээний группийн дарга	1
5. Орон сууц, нийтийн аж ахуй, шугам сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтэн	4
6. Цагдан сэргийлэх группийн дарга	1
7. Цагдан сэргийлэх группийн сэргийлэгч, автын байцаагч	4
8. Бүртгэл тайлан, төлөвлөлтийн группийн дарга	1
9. Төсвийн мэргэжилтэн	1
10. Бичээч	1
11. Жолооч	1
12. Сахиул	15
ДҮН	32



БНМАУ-ын Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1989 оны 4 дүгээр сарын 15 -ны өдрийн хамтарсан хурлын 143/77 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

МААНЬТ ХОТХОНЫГ ХҮЛЭЭЖ АВАХ БЭЛТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ХОЛБОГДОХ АСУУДЛЫГ СУДАЛЖ БОЛОВСРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын даргад Л.Энэбил -Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга
- Нарийн бичгийн даргад: Б.Баярсайхан -ЭЗГХХЯ-ны Хөрөнгө оруулалт агуулахын аж ахуйн механикжуулалтын хэлтсийн дарга
- Гишүүдэд:
 - Ж.Гэлгөө -ЭЗГХХЯ-ны орлогч сайд
 - Б.Жигжид -НААҮЯ-ны орлогч сайд
 - Ш.Чимэгжанцан-ХБЯ-ны орлогч сайд
 - А.Пүрэвжав -Зам тээврийн яамны орлогч сайд
 - Д.Занаа -Холбооны яамны орлогч сайд
 - С.Авирмэд -Батлан хамгаалах яамны орон сууцны хэлтсийн инженер, дэд хурандаа
 - Г.Маналжав -Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Зохион зааварлах хэлтсийн дарга
 - Д.Гонгор -Санхүүгийн хэлтсийн дарга
 - С.Батмагнай -Ардын боловсролын удирдах газрын дарга
 - П.Бямбаа -Эрүүлийг хамгаалах газрын дарга
 - Б.Бизъяа -Соёлын хэлтсийн дарга
 - Ч.Санжжав -Цэргийн хэлтсийн дарга
 - Ц.Баасанжав -Хотын ОСНААУ газрын дарга
 - С.Энэбил -ТЭЗУХ-ны инженер техникийн газрын ажилтан
 - Ж.Шагдарсүрэн-Эрчим хүчний системийн ерөнхий инженер
 - Г.Бадарч -ХБХН-ийн дарга
 - Д.Мижиддорж -АҮБХН-ийн дарга
 - Ц.Урианхай -НХУГ-ын дарга
 - Ц.Надмид -АУУГ-ын дарга
 - Ч.Баасандорж -УСАУГ-ын дарга
 - Д.Дашдондог -МЭХАГ-ын орлогч дарга